



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/360

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан ЕБС-ийн англи хэлний ленгифоны танхим тохижуулах (Хутаг-Өндөр сум, Хангал сум Хялганат тосгон, Булган сумын 1, 2, 3 дугаар сургууль) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Санко маркетинг монголиа” ХХК-тай 409 594 000 (Дөрвөн зуун есөн сая таван зуун ерэн дөрвөн мянга) төгрөгөөр гэрээ байгуулахыг эрхийг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Санко маркетинг монголиа” ХХК-ийн захирал (Г.Нямдэлгэр)-д даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010341

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын  
09 өдрийн 36 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.05 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
2	Ажил гүйцэтгэх хугацаа	30 хоног	Ж.Ганболд
3	Гүйцэтгэлийн баталгааны дүн	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Д.Батцогт